



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 231

Улаанбаатар хот

“Женерал пропертиз” ХХК-д хувьцаа эзэмшигчдийн  
бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг  
зөвшөөрөх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын 4.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Женерал пропертиз” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Женерал пропертиз” ХХК /Э.Оргил/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба/Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

151800000383

Санхүүгийн зохицуулах хорооны 2022  
оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн  
201 дүгээр тогтоолын хавсралт



“Женерал пропертиз” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд орох өөрчлөлт

/төгрөгөөр/

№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс /регистрийн дугаар/	Нэрлэсэн үнэ	Хувьцааны эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Хувьцааны эцсийн үлдэгдэл		
			Тоо ширхэг	Үнийн дүн	Эзлэх хувь	Хувьцааны тоо	Үнийн дүн	Тоо ширхэг	Үнийн дүн	Эзлэх хувь
1	Э.Оргил /ЦЖ81112673/	1000.00	6,000	6,000,000.00	40%	(6,000)	(6,000,000.00)	-	-	-
2	Ц.Лхамжав /ЧД73101867/	1000.00	9,000	9,000,000.00	60%	6,000	6,000,000.00	15,000	15,000,000.00	100%
	Нийт	-	15,000	15,000,000.00	100%	-	-	15,000	15,000,000.00	100%